

## **“Хот Девелопмент” ХК-ийн 2016 оны жилийн үйл ажиллагааны тайлан**

Нэр: “Хот Девелопмент” ХК

Хаяг: Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-13, Лэндмарк билдинг, 4 давхар

Утас: 75753302, 88009111

Улсын бүртгэлийн дугаар:	9010387001
Регистрын дугаар:	2116812
Үйл ажиллагааны чиглэл:	Бизнесийн зөвлөгөө, гадаад худалдаа
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	44 хувьцаа эзэмшигчид 39,885 хувьцаа эзэмшиж байна /2016. 03.18-ны өдрийн тархалтын судалгаа/

### Үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, хэрэгжүүлж буй төсөл:

“Хот девелопмент” ХК нь 2016 онд үйл ажиллагаагаа хэвийн явуулж цаашид компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, шинэ салбарт үйл ажиллагаагаа эхлүүлэх ажлыг хийж ирлээ. 2013 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээг барьж цаашид Чойр өртөөнд Ложистик төв байгуулах ажлыг санхүүжүүлэх, бүтээн байгуулалтанд шаардлагатай хөрөнгө оруулалтыг босгохоор төлөвлөн ажиллаж байна. Энэхүү төсөл нь нийт 40 га газрыг хамран байрлах төмөр замд холбогдох боломжтой гэдгээрээ онцлог юм. Компани одоогоор орон тоо болон бүтэц нэмэгдүүлээгүй бөгөөд тайлант хугацаанд СиБиЭм ХХК-р Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг гүйцэтгэн ажиллаж байна.

Гол хувьцаа эзэмшигч Файрбөрд хөрөнгө оруулалтын сангаас авсан 200,000 ам долларын хөрвөх зээлийг хөрвүүлээгүй байгаа бөгөөд цаашид нэмэлт хувьцаа гаргах компанийн үнэн цэнийг өсгөх зорилгоор уг хөрвүүлэлтийг хийх төлөвлөгөөтэй байна.

### Санхүүгийн тайлангийн узуулэлт:

Компани санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татварын тайлан тооцоог цаг хугацаанд нь гаргаж, дүүргийн санхүүгийн хэлтэс, татварын байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.

Санхүүгийн үйл ажиллагаанд одоогоор гарсан томоохон гүйлгээ үл хөдлөх хөрөнгө худалдан авалт хийгдээгүй байна.

Тус компани нь одоогоор ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байгаа тул 2016 оны байдлаар 44,106,455.76 төгрөгийн зардал гаргаж, 171,252,197.82 төгрөгийн алдагдалтай ажиллаж байна. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө оны эхэнд 13,432,705.64 төгрөг хагас жилийн эцсийн үлдэгдэл 15,897,089.93 төгрөг байна.

<b>№</b>	<b>Үлдэгдлийн тэнцэл</b>	<b>01 сарын 01</b>	<b>12 сарын 31</b>
1	Мөнгөн хөрөнгө	13,432,705.64	15,897,089.93
2	Авлага	14,887,500.00	14,887,500.00
	<b><u>Эргэлтийн хөрөнгийн дүн</u></b>	<b>28,320,205.64</b>	<b>30,784,589.93</b>
3	Үндсэн хөрөнгө	-	-
4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	219,412,500.00	219,412,500.00
	<b><u>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</u></b>	<b>219,412,500.00</b>	<b>219,412,500.00</b>
	<b><u>Нийт хөрөнгийн дүн</u></b>	<b>247,732,705.64</b>	<b>250,197,089.93</b>
5	Богино хугацаат зээл	399,196,000.00	497,906,000.00
6	Хүүний өглөг	101,384,945.85	176,381,656.96
7	Бусад богино хугацаат өр төлбөр	59,919.60	69,790.60
	<b><u>Өр төлбөрийн дүн</u></b>	<b>500,640,865.45</b>	<b>674,357,447.56</b>
8	Эзний өмч	3,988,500.00	3,988,500.00
9	Хуримтлагдсан ашиг	(256,896,659.81)	(428,148,857.63)
10	<b><u>Эзэмшигчийн өмчийн дүн</u></b>	<b>(252,908,159.81)</b>	<b>(424,160,357.63)</b>
	<b><u>Өр төлбөр ба эздийн өмч</u></b>	<b>247,732,705.64</b>	<b>250,197,089.93</b>
	<b>б. Орлого үр дүнгийн тайлан</b>		<b>12 сарын 31</b>
11	Цэвэр борлуулалт		-
12	ББӨ		-
13	Нийт ашиг		-
14	Хүүгийн орлого		-
15	Ерөнхий ба удирдлагын зардал		672,842.64
16	Санхүүгийн зардал		43,433,613.12
17	Бусад зардал		-
18	Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз )		(127,145,742.06)
19	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз )		-
20	<b><u>Татвар төлөхийн өмнөх ашиг</u></b>		<b>(171,252,197.82)</b>
21	Орлогын татварын зардал		-
22	<b><u>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )</u></b>		<b>(171,252,197.82)</b>

Ноогдол ашгийн талаарх мэдээлэл:

Компани 2016 онд алдагдалтай ажилласан тул ноогдол ашиг тараагаагүй болно.

Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаархи мэдээлэл:

Компани их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй.

Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

Хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Нийт хувьцааны хувь
1	HOT HOLDINGS S.A.R.L	74,53%
2	БиДиСек ХК	7,48%

Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын тайлан:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Батбаатар, Жэймс Пассин, Б.Пүрэвбаатар, Б.Лхагвадорж, Д.Даянбилгүүн, Жэймс Флорес, хараат бус гишүүдээр Б.Батхуяг, Д.Нарангоо, Т.Тамир, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Батбаатар, Гүйцэтгэх захирлаар Б.Пүрэвбаатар улиран сонгогдож, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ж.Энхцэцэг нар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

Үнэт цаас гаргачийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга

№	Овог, нэр	Албан тушаал	Боловсрол
1	Бадан овогтой Батбаатар	ТУЗ-ийн дарга	дээд
2	Жэймс Пассин	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
3	Баярсайхан овогтой Пүрэвбатаар	ТУЗ-ийн ердийн гишүүн, Гүйцэтгэх захирал	дээд
4	Жэймс Флорес	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд

5	Бүрэнмэнд овогтой Лхагвадорж	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
6	Данзан овогтой Даянбилгүүн	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд
7	Тэрбиш овогтой Тамир	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
8	Дармаа овогтой Нарангоо	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
9	Батболд овогтой Батхуяг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд
10	Жаргал овогтой Энхцэцэг	ТУЗ-ийн нарийн бичиг	дээд

“Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2016 оны 04 сарын 15-ны өдөр** хуралдаж компанийн ТУЗ-ийн гишүүдийн томилох, 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан батлах, 2016 оны бизнес төлөвлөгөө батлах, 2016 оны ТУЗ-ын төсөв батлах зэрэг асуудлаар хэлэлцсэн юм. Уг хуралд нийт саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдийн 82,02 хувь санал ирүүлсэн бөгөөд хэлэлцэж буй асуудалтай холбогдож гаргасан хурлын шийдвэрийг 100 хувийн саналаар баталсан байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд **2016 оны 05 сарын 23-ны өдөр** Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын дэд хороог Б.Батхуяг, Жэймс Флорэс, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Батхуягийг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Б.Лхагвадорж, Д.Нарангоо, Т.Тамир гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Б.Лхагвадоржийг томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хороог Жэймс Пассин, Б.Батхуяг, Т.Тамир гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Жэймс Пассиниыг томилсон.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2016 онд гишүүдийн орон зайгаас шалтгаалан ТУЗ-ийн хурлыг онлайн болон гишүүд оролцсон хоёр хэлбэрээр хийж байсан. Дээрхи хугацаанд нийт 4 удаа хуралдаж 7 тогтоол батлагдаж гарсан.

- Ногдол ашиг хувиарлах эсэх тухай компанийн санхүү эдийн засагтай холбоотой 1 асуудал.

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах, аудитын байгууллага сонгох, ТУЗ-ын дарга, ТУЗ-ын нарийн бичиг, Гүйцэтгэх захирал томилох, ТУЗ-ын аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо болон цалин урамшууллын хороо сонгох тухай компанийн удирдлага зохион байгуулалтын чиглэлээр б асуудал хэлэлцэж шийдвэр гаргаж байсан.

“Хот девелопмент” ХК **2015 оны 04 сарын 16**-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2015 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2015 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

“Хот девелопмент” ХК **2014 оны 04 сарын 21**-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2014 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах